

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
АЖЛЫН ТАЙЛАН**

2023 оны 4 сарын 15-ны өдөр

Т.Батмагнай миний бие Тээвэр хөгжлийн банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2023 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн ажиллаж байна.

ТУЗ-ын хараат бус гишүүнээр ажиллахдаа “Банкны тухай хууль”, “Компанийн тухай хууль”, болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, “Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” зэргийг тус тус хэрэгжүүлэн ажилласан болно.

2023 оны 01 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал 4 удаа хуралдаж хараат бус гишүүний хувьд дараах асуудлуудыг шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон. Үүнд:

1. ТУЗ-ын дэргэдэх Аудитийн хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Хүний нөөц, цалин урамшуулалын хорооны бүрдлэхүүнийг томилж шинэчлэн батлав.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Үйл ажиллагааны журамд нэмэлт оорчлолт оруулан шинэчлэн батлав.
3. Банкны Гүйцэтгэх захирлаар Б. Энэрэлтийг нэр дэвшүүлэн Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцөхөөр холбогдох баримт бичгийг хүргүүлэхээр шийдвэрлэв.
4. Чанаргүй зээлийн үлдэгдлийг эрсдэлийн сангаас хаах асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хуралдуулахаар товлон.
5. Банкны 2023 оны Бүтэц, орон тоо, цалингийн шатлалыг шинэчлэн батлав.
6. Япон улс, Токио хотод төлөөлөгчийн газар байгуулахыг зөвшөөрч, тус ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн цаг тухайд нь зохион байгуулах, зохих баримт бичгийг бүрдүүлж Монголбанкинд хүргүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.
7. Дотоод Аудитын газрын 2023 оны ажлын төлөвлөгөөг батлав.

8. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албаны хуульч өөр ажилд шилжиж байгаатай холбоотой хуулчийн үүрэгт ажлаас чөлөөлөхөөр шийдвэрлэв.

9. Банкны “Тогтвортой санхүүжилтийн бодлого”, “Жендерийн эрх тэгш байдлын бодлого” болон “Банкны 2023 оны Бизнес төлөвлөгөө”-г тус тус батлав.

10. Банкны Гүйцэтгэх захирлаар Б.Энэрэлтийг Монголбанкны зөвшөөрлийг үндэслэн 2023 оны 1 дүгээр сарын 23-наас томилохоор шийдвэрлэв.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хуралдуулахаар зарлаж, хурлаар банкны 2022 оны Хөндлөнгийн Аудитын тайлан, ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, ногдол ашиг хуваарилах эсэх тухай, банкны 2022 оны жилийн үйл ажиллагааны талаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

12. МУГСТ чиглэсэн дотоод хяналтын бодлого болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг батлав.

13. Банкны өмчлөлд байгаа тээврийн хэрэгслийг худалдан борлуулах асуудлыг хэлэлцүүлэхээр ХЭ-ийн ээлжит бус хурлыг 2023.03.28-ны өдөр зарлахаар шийдвэрлэв.

14. Дотоод аудитын газрын захирал ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасны дагуу үүрэгт ажлаас чөлөөлж, Х.Баттулгыг 2023.04.03-ны өдрөөс Дотоод аудитын газрын захирал албан тушаалд томилохоор шийдвэрлэв. Мөн Ерөнхий аудитийн албаны захирлаар Д.Бямбажавыг томилохоор шийдвэрлэв.


15. ТУЗ-ын баталсан банкны 2023 оны орон тооны төлөвлөлт, албан тушаалын нэршилд нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэв.

16. Банкны 2 зээлдэгчийн үндсэн зээл, хүүний үлдэгдлийг барагдуулахаар барьцаа хөрөнгийг хураан авч банкны ӨБХХ дансанд бүртгэхээр шийдвэрлэсэн бөгөөд холбогдох журам, зааврын дагуу бүртгэж, зөрүү төлбөр үүссэн тохиолдолд зээлдэгчээр төлүүлэх, холбогдох гэрээ байгуулах, эрх зүйн шаардлагыг бүрэн хангаж ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгов.

ТУЗ-ын хурлаар дээрх асуудлуудыг хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргахад ТУЗ-ын хараат бус гишүүний хувьд саналын зөрүүтэй зүйл байгаагүй болно.

Тээвэр Хөгжлийн Банкны

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Т. Батмагнай